



Монголын Усан Спорт
Сонирхогчдын Холбоо

ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ДҮРЭМ

2023 ОНЫ 11 САРЫН 17-НЫ
ӨДРӨӨС ХҮЧИН ТӨГӨЛДӨР
ҮЙЛЧИЛНЭ

МУССХ-НЫ ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ДҮРЭМ

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
1. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
2. ХАРЬАЛАЛ.....	4
3. ТОДОРХОЙЛОЛТ.....	4
Б БҮЛЭГ – ДҮРЭМ.....	6
4. ХОРИГЛОСОН ЗАН, ЗҮЙЛ	6
5. ДҮРМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ.....	7
6. ШИЙТГЭЛ.....	9
7. ДҮРМИЙН ХЭРЭГЖИЛТ.....	11
8. ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА	11
9. ШИЙДВЭРИЙГ ДАВЖ ЗААЛДАХ	11
10. ДҮРМИЙГ ӨӨРЧЛӨХ, ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ	12

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ – НИЙТЛЭГ ТОДОРХОЙЛОЛТ

МУССХ нь холбооны бүхий л үйл ажиллагаанд оролцогчдыг сэтгэл хангалуун байлгах эрүүл, эерэг спортын орчныг бий болгохыг эрхэмлэнэ. Үүний тулд оролцогч бүх талуудын эрх болон аюулгүй байдлыг үргэлж дээдлэн ажиллана.

МУССХ нь Дэлхийн усан спортын холбоо буюу World Aquatics-ын үндэсний гишүүн байгууллагын хувьд Олон улсын олимпийн хорооны 2016 оны “Спортын дарамт, хүчирхийллийн эсрэг” зөвлөмжийн хүрээнд энэхүү дүрмийг баталлаа.

МУССХ-ны “Хүчирхийллийн эсрэг дүрэм” нь тамирчдын аюулгүй байдлыг хангаж, бүх төрлийн хүчирхийлэл дарамтаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой.

Энэхүү дүрэм нь тамирчид болон түүнийг туслан дэмжигчдийн (үүнд: дасгалжуулагч, менежер, агент, багийн гишүүд, албаны хүмүүс, багийн эмч гэх мэт) хоорондын харилцааны хэм хэмжээ болон аливаа зөрчлийн үйлдлийг заавал мэдээлэх, гомдол мэдээллийг шалган шийдвэрлэх бүтэц тогтолцоог тодорхойлно.

МУССХ нь гишүүдээ дарамт, хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, аюулгүй спортын орчинг бий болгохын тулд мэдээлэл хүлээн авах сувгийг бий болгох, мэдлэг боловсрол олгох, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, энэ талаархи судалгааны ажлыг дэмжиж ажиллана.

Энэхүү дүрмийн хэрэгжилтийг МУССХ-ны Ёс зүйн зөвлөл хариуцан ажиллах бөгөөд бүхий л үйл ажиллагаагаа хараат бусаар явуулна.

Үйлчлэлд хамаарах этгээд нь энэхүү дүрэмтэй танилцаж, дагаж мөрдөх, эрх бүхий бүтцийн шийдвэрийг дагаж биелүүлэх үүрэгтэй.

МУССХ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрмэнд нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй бөгөөд энэ нь Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны холбогдох дүрэм журмын хэм хэмжээнд байна.

Энэхүү дүрэм болон түүнд орсон аливаа нэмэлт, өөрчлөлт нь батлагдсан цагаасаа шууд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд өөрийн мэдээллийн сувгаар олон нийтэд мэдээлнэ.

Нэгдүгээр зүйл. ХАМРАХ ХҮРЭЭ

- 1.1 Энэ дүрэм нь МУССХ-ны дүрмийн үйлчлэлд хамаарах бүхий л этгээдэд үйлчилнэ.
- 1.2 Үйлчлэлд хамаарах этгээд холбооны бүхий л арга хэмжээнд бэлтгэх, туслах, оролцож байх үедээ энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.
- 1.3 Үйлчлэлд хамаарах этгээд энэхүү дүрмээр хориглосон аливаа зан үйл болон шаардлагуудыг сайтар ойлгон мэдэж, дагаж биелүүлэх үүргийг хүлээнэ. Үйлчлэлд хамаарах этгээд нь энэхүү дүрмээр хориглосон зан үйл нь Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд гэмт хэрэгт тооцогдож болохыг анхаарч тухайн хууль тогтоомжийг энэхүү дүрмийн нэгэн адил сахин биелүүлэх үүрэгтэй.

Хоёрдугаар зүйл. ХАРЬЯАЛАЛ

2.1 Үйлчлэлд хамаарах этгээдийн Холбооны арга хэмжээний үеэр гаргасан нэг буюу хэд хэдэн хүчирхийллийн зан үйл нь МУССХ болон түүний Ёс зүйн зөвлөлийн эрх мэдлийн хүрээнд хамаарагдана.

2.1.1 Хэрэв аливаа хориотой зан үйл нь Холбооны болон холбооны бус арга хэмжээг дамнан үйлдэгдсэн бол тухайн зөрчлийн эх үүсвэр болон үргэлжилсэн хугацааны ихэнх нь Холбооны арга хэмжээний үеэр болсон тохиолдолд л энэхүү дүрмийн үйлчлэлд хамааруулан асуудлыг шийдвэрлэнэ.

2.1.2 Хэрэв аливаа хориотой зан үйл нь Холбооны бус арга хэмжээний үеэр үйлдэгдсэн эсвэл үйлчлэлд хамаарах этгээд үйлдээгүй бол энэ асуудлыг МУССХ-ны эрхлэх асуудалд хамааруулан тооцохгүй. Энэ тохиолдолд маргалдагч талууд өөрсдийн харьяалагдах спортын холбоо болон эрх бүхий хуулийн байгууллагын хүрээнд асуудлаа шийдвэрлүүлнэ.

2.2 МУССХ болон түүний Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг зөвхөн Швейцарийн Лозанн хотод байрлах Олон улсын спортын арбитрын шүүхэд (CAS) л давж заалдаж болно. Олон улсын арбитрын шүүх нь энэхүү асуудлаар шийдвэр гаргах онцгой бүрэн эрхийг эдэлнэ.

2.3 Хэрэв өөрийн "Хүчирхийллийн эсрэг дүрэм"-тэй спортын наадам, томоохон арга хэмжээний үеэр:
а) Үйлчлэлд хамаарах этгээдийн эсрэг гаргасан хориотой зан үйлийн талаархи гомдол, мэдээлэл тухайн арга хэмжээг зохион байгуулагчдад анх ирсэн бол, б) Хориотой зан үйл тус спортын наадам, үйл ажиллагааны үеэр гарсан гэдэг нь нотлогдож байгаа бол тус асуудлыг тус спортын наадам, арга хэмжээний холбогдох дүрмийн хүрээнд шийдвэрлүүлнэ.

Гуравдугаар зүйл. ТОДОРХОЙЛОЛТ

3.1 **Ёс зүйн зөвлөл:** МУССХ-ны дүрмийн 13.4 зүйлд заасны дагуу бий болсон бүтэц

3.2 **Нэхэмжлэгч:** Хориотой зан үйлийн хохирогч болсон үйлчлэлд хамаарах этгээд (эсвэл нэхэмжлэгч насанд хүрээгүй тохиолдолд түүний хууль ёсны асран хамгаалагч)-ийг хэлнэ.

3.3 **Холбооны арга хэмжээ:** МУССХ болон түүний гишүүн байгууллага клубын зохион байгуулж буй усан спортын тэмцээн, хурал зөвөлгөөн, уулзалт, бусад бүх төрлийн арга хэмжээ, усан спортын төрөл хөтөлбөрт нь багтсан спортын наадам, үйл ажиллагаа

3.4 **Үйлчлэлд хамаарах этгээд:** холбооны арга хэмжээнд оролцож байгаа, эсвэл оролцож байгаа хүнийг туслан дэмжиж, бэлтгэж байгаа доорхи ангиллын аль нэгэнд хамаарах хүн

3.5.1 "Тамирчин" гэж тэмцээнд оролцож байгаа эсвэл тэмцээнд оролцох шаардлага хангасан аливаа хүн, бүлэг хүмүүс

3.5.2 "Тамирчныг туслан дэмжигч" тамирчныг усан спортын тэмцээн уралдаанд бэлтгэн оролцуулж буй дасгалжуулагч, менежер, агент, багийн гишүүд, албаны хүмүүс, багийн эмч гэх мэт тамирчинтай ажилладаг бүх хүн

3.5.3 "Албан тушаалтан" гэж Холбооны сонгогдсон болон томилогдсон бүх албан тушаалтнууд, ажилтнууд, шүүгчид, арга хэмжээний зохион байгуулалтанд оролцож буй хүмүүс, зөвлөхүүд, тамирчинтай харьцах эрх бүхий бүх этгээд

3.6 **Хориотой зан үйл:** Дөрөвдүгээр зүйлд заасан аливаа үйлдэл

3.7 **Бие даан мөрдөх ажиллагаа:** Ёс зүйн зөвлөлөөс болзошгүй зөрчлийн хэргийг шалгуулахаар томилсон зөвлөлийн гишүүний үйл ажиллагаа

3.8 **Спортын наадам, томоохон арга хэмжээ:** Олон спортын төрлийг хөтөлбөртөө багтаасан арга хэмжээг хэлнэ. Жишээ нь: Хүүхдийн спортын наадам, олимпийн наадам, азийн наадам гэх мэт

3.9 **Гишүүд:** МУССХ-ны зорилго, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, гишүүний татвараа төлсөн хувь хүн болон усан спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, клубууд

3.10 **Насанд хүрээгүй:** 18-аас доош насны хүн

3.11 **Холбооны бус арга хэмжээ:** МУССХ-ноос зохион байгуулаагүй болон усан спортын төрөл багтаагүй бусад спортын наадам, уралдаан тэмцээн, үйл ажиллагаа

3.12 **Дүрэм:** Хүчирхийллээс хамгаалах тухай энэхүү дүрэм

ХОЁРДУГААР БҮЛЭГ – ДҮРЭМ

Дөрөвдүгээр зүйл. ХОРИОТОЙ ЗАН ҮЙЛ

4.1 Доорхи хориглосон үйлдлүүд нь энэхүү дүрмийн зөрчил болно.

4.1.1 Хүчирхийлэл

Гутаан доромжлох, үл тоомсорлох, сэтгэл зүйн болон бие махбодийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүчирхийлэл. Дарамт, хүчирхийллийн эдгээр хэлбэрүүд нь хамтдаа хавсарч тохиолдож болно.

4.1.2 Гутаан доромжлох

Үйлчлэлд хамаарах этгээдийн хүсэл зоригоос үл шалтгаалан түүний бие махбодь, сэтгэл зүйд гэмтэл учруулах эсрсдэлтэй санаатай, санамсаргүй хийсэн аливаа үйлдлүүд.

4.1.3 Үл тоомсорлох

Үйлчлэлд хамаарах этгээдийг асран халамжлах, хамгаалах үүргээ дутуу биелүүлсэн эсвэл ялгаатай байдлаар биелүүлснээс болж үйлчлэлд хамаарах этгээдэд сэтгэл санаа, бие махбодийн хохирол учруулж болзошгүй аливаа үйлдэл.

Жишээ нь: аюулгүй байдлыг хангаагүй байгууламж, тоног төхөөрөмж болон хэт халуун, хүйтэн, аюултай нөхцөлд бэлтгэл сургуулилт хийлгэх, бэлтгэлийн үеэр шаардлагатай хэмжээний шим тэжээл, шингэн нөхөх зүйлээр хангахгүй байх, албадан бэлтгэл хийлгэх

4.1.4 Сэтгэл зүйн хүчирхийлэл

Үйлчлэлд хамаарах этгээдийн бие махбодьд халдаагүй боловч эрх мэдлийн ялгаатай байдлаа санаатайгаар, удаан үргэлжилсэн, давтамжтайгаар мэдрүүлэх аливаа үйлдэл. Хүчирхийллийн энэ хэлбэр нь бусад бүх төрлийн хүчирхийллийн суурь үндэс болдог.

4.1.5 Бие махбодийн хүчирхийлэл

Үйлчлэлд хамаарах этгээдийн бие махбодьд гэмтэл учруулж болзошгүй цохих, өшиглөх, хазах гэх мэт бүх үйлдлүүд. Мөн нас хүйс, бие махбодийн онцлогт тохироогүй гэмтээх, өвдөлт мэдрүүлэх аливаа дасгал сургуулилтыг хийлгэх, хийхийг албадах, согтууруулах ундаа болон сэргээш хэрэглэхийг албадах

4.1.6 Бэлгийн дарамт

Үйлчлэлд хамаарах этгээдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үг хэллэг, бие махбодийн аливаа үйлдэл. Бэлгийн дарамт нь ил тод тулган шаардсан эсвэл далд хэлбэрээр үйлдэлдэж болно.

4.1.7 Бэлгийн хүчирхийлэл

Бэлгийн шинж чанартай аливаа зан үйлийг тулган шаардаж, хуурч мэхлэх замаар хүрэлцэж, хүрэлцэхгүйгээр үйлдэх. Үүнд: үнсэх, биеийн эмзэг хэсэгт хүрэх, шүргэх гэх мэт бүх үйлдлийг багтаан ойлгоно.

4.2 Доорхи зан үйлийг энэхүү дүрмэнд заасан зөрчилд хамааруулан тооцож шийдвэрлэхгүй. Үүнд: усан сан бол түүний тоног төхөөрөмжийн асуудал, санхүүгийн асуудал болон спортын өрсөлдөөн, оноотой хамааралтай маргаан, хөдөлмөрийн харилцааны асуудлууд. Түүнээс гадна тамирчдын бие бялдар, ур чадварыг сайжруулах болон сахилга бат, баг хамт олныг бүрдүүлэх хүлээн зөвшөөрөгдсөн дасгалжуулалтын арга барилыг хориглосон зан үйлд хамааруулан ойлгохгүй.

Тавдугаар зүйл. ДҮРМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

5.1 Мэдээлэх

Хэн ч энэхүү дүрмийн зөрчилтэй холбоотой зан үйлийн талаархи гомдол, нэхэмлэлийг гаргаж болно. Мэдээлэгч (цаашид нэхэмжлэгч гэх) нь холбооны арга хэмжээний үеэр, үйлчлэлд хамаарах этгээдийн гаргасан аливаа дарамт, хүчирхийллийн болзошгүй зан үйлийн талаархи мэдээллийг Ёс зүйн зөвлөл эсвэл түүний гишүүнд бичгээр болон амаар өгч болно. Бичгээр гаргасан гомдол мэдээлэлд доорхи мэдээллүүдийг заавал тусгасан байх шаардлагатай бөгөөд Ёс зүйн зөвлөлийн албан ёсны цахим шуудангийн хаягаар давхар илгээсэн байна. Үүнд:

- Дүрмийн 5.2-т заасан нэхэмжлэгч (насанд хүрээгүй бол хууль ёсны асран хамгаалагч)-ийн овог нэр, албан тушаал, хаяг, холбоо барих мэдээлэл, гарын үсэг;
- Хориотой зан үйл үйлдсэн гэх үйлчлэлд хамаарах этгээдийн нэр, овог;
- Хориотой зан үйл үйлдэгдсэн гэх огноо, байршил (ууд) зэргийг багтаасан хэрэг явдлын талаархи бүрэн бодит тайлбар;
- Нэхэмжлэгчийн мэдээлж буй хориотой зан үйл гарсныг батлах аливаа нотлох баримт;
- Зөрчсөн гэж үзэж буй энэхүү дүрмийн заалтууд.

5.2 Нэргүй мэдээлэл

Энэхүү дүрмийн дагуу нэргүй мэдээллийг хүлээн авч болно. Мэдээллийг хүлээж авсан Ёс зүйн зөвлөлийн гишүүн болон зөрчлийг шалгаж шийдвэрлэх бусад этгээдүүд нэхэмжлэгчийн хувийн мэдээллийг мэдэхгүй байхыг нэрээ нууцлах гэнэ. Аливаа нэргүй мэдээлэл нь зөрчлийн зан үйлийг шалган шийдвэрлэхэд төвөгтэй байдлыг бий болгодог учир нэхэмжлэгчийг аль болох нэр, хаягаа нууцлахгүй байхыг МУССХ дэмжин ажиллана. Нэхэмжлэгчийн хувийн бүх мэдээлэл ямагт нууц байх бөгөөд зөвхөн зайлшгүй шаардлагатай үед өөрийнх нь бичгээр гаргасан зөвшөөрлийн дагуу мэдээллийг задруулж болно.

5.3 Гомдол, мэдээллийг хүлээн авах

Ёс зүйн зөвлөл, түүний гишүүн нь хориотой зан үйлийн талаархи мэдээллийг хүлээн авмагц энэхүү дүрмийн харьяалалд хамаарах эсэхийг тодорхойлж мөн гэж үзвэл энэ талаар хариуцагч талын харьяалах байгууллага, клубт нэхэмжлэгчээс ирүүлсэн мэдээллийн хамт хүргүүлж хариу тайлбараа ирүүлэхийг хүснэ.

Харьяалах байгууллага, клуб нь хариуцагчид энэ тухай яаралтай мэдэгдэж Ёс зүйн зөвлөлийн шалган, шийдвэрлэх үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллана.

5.4 Талууд

Энэхүү дүрмийн дагуу талууд нь гомдол мэдээлэл гаргагч буюу нэхэмжлэгч, нөгөө талд буруутгагдаж байгаа үйлчлэлд хамаарах этгээд (хариуцагч) байна.

Нэхэмжлэгч болон хариуцагч хоёул шалгах ажиллагааны үеэр хамтран ажиллах шаардлагатай боловч энэхүү дүрмийн дагуу шийдвэр гаргах үйл явцад оролцохгүй. Талууд шалгах ажиллагаанд хамтран ажиллах нь хэргийн бодит үнэнийг тогтоох, нотлох баримтын дагуу зөрчил гарсан эсэх шийдвэрийг үнэн зөв гаргахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Хэрэв нэхэмжлэгч болон хариуцагч шалгах ажиллагаанд хамтран ажиллахаас татгалзвал Ёс зүйн зөвлөл нь өөрт байгаа мэдээлэл болон нотлох баримтын хүрээнд шийдвэрээ гаргана. Эсвэл болзошгүй зөрчлийг шалгах ажиллагаа хийхгүй байх шийдвэрийг гаргаж болно.

Нэхэмжлэгч нь шалгах ажиллагаа болон сонголд оролцохоос татгалзсан эсвэл ямар нэг шалтгаанаар оролцох боломжгүй болсон тохиолдолд нэхэмжлэлийг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал болно. Гэвч энэ нь шалган шийдвэрлэх ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй бөгөөд Ёс зүйн зөвлөл нэхэмжлэгчийн оролцоогүйгээр хийх боломжтой бүхий л арга замаар баримт нотолгоо (бичлэг, гэрчийн мэдүүлэг, бие махбодийн баримт нотолгоо), мэдээллийг цуглуулж ажиллана.

Ёс зүйн зөвлөл нь нэхэмжлэгч болон хариуцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын тулд тэдний асран хамгаалагчдад хориотой зан үйлийн зөрчлийн талаархи мэдээллийг шуурхай өгөх эрхтэй.

5.5 Шалгах ажиллагаа

Гомдол мэдээлэл ирсний дараа нэхэмжлэгч болон хариуцагч хоёул хариу тайлбар, нотлох баримт гаргах, шалгах ажиллагаанд туслах гэрчийг дуудаж мэдүүлэг өгүүлэх боломжоор хангагдах ёстой. Шалгах ажиллагааны явцад нэхэмжлэгч болон хариуцагч нь өөрт байсан мэдээлэл болон нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол тухайн баримт мэдээллийг зөрчлийг шийдвэрлэх ажиллагаанд ашиглахгүй. Энэ мэдээлэл нь шалгах ажиллагаа дууссаны дараа ирсэн бол сонсох ажиллагаанд ашиглаж болох ч зөрчлийг шийдвэрлэх гол хүчин зүйлийн хэмжээнд үнэлэхгүй.

5.6 Бие даасан шалгах ажиллагаа

Ёс зүйн зөвлөл нь нэмэлт баримт нотолгоо шаадлагатай гэж үзвэл бие даан мөрдөн шалгах ажиллагааг явуулах хүнийг өөрийн гишүүдийн бүрэлдэхүүнээс томилж болно. Тухайн гишүүн шалгах ажиллагааныхаа үр дүнд олж авсан нотлох баримт, мэдээллийн тайлан болон дүгнэлт, зөвлөмжийг Ёс зүйн зөвлөлд ирүүлэх бөгөөд хувийг нэхэмжлэгч болон хариуцагчид хүргүүлнэ.

5.7 Шийдвэр гаргах аргууд

5.7.1 Хэргийг хаах

Бие даасан шалгах ажиллагааг явуулсан ёс зүйн зөвлөлийн гишүүн тухайн хэргийг энэхүү дүрмэнд харьяалахгүй, баттай баримт нотолгоо байхгүй, нэхэмжлэгч тал шалгах шийдвэрлэх ажиллагаанд хамтран ажиллахаас татгалзсан болон бусад хүчин зүйлийг үндэслэн өөрийн үзэмжээр хаах шийдвэр гаргаж болно. Хэрэв шинээр баримт мэдээлэл, нотолгоо олдсон, хэргийн нөхцөл байдал өөрчдөгдсөн тохиолдолд хэргийг дахин шалгаж болно.

5.7.2 Түргэвчилсэн журмаар шийдвэрлэх

Хориотой зан үйлийн зөрчилд буруутгагдаж байгаа этгээд асуудлыг шийдвэрлэгдэж дуусахаас өмнө хэдийд ч өөрийн гэм бурууг хүлээж дүрмэнд заасан хариуцлагыг хүлээхээ илэрхийлж болно. Энэ тохиолдолд хэргийг шалгаж буй Ёс зүйн зөвлөлийн гишүүн талуудын саналыг сонсож, дүрмийн 6 дугаар зүйлд заасан шийтгэлүүдээс аль тохирохыг оноож шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэр нь эцсийн шийдвэр байх бөгөөд хэргийг үүгээр шийдвэрлэж дууссанд тооцно. Түргэвчилсэн журмаар шийдвэрлэсэн шийдвэрийг холбооны албан ёсны мэдээллийн сувгаар мэдээлнэ.

5.7.3 Албан ёсны шийдвэр

Бие даасан шалгах ажиллагаа дууссаны дараа цугуулсан баримт нотолгоон дээр үндэслэн Ёс зүйн зөвлөл шийдвэрээ гаргана. Ингэхдээ хоёр талын мэдүүлэг тайлбарыг сонсоно. Хэрэв Ёс зүйн зөвлөл хориотой зан үйлд буруутгасан нэхэмжлэлд дурдсан мэдээлэл худал, үндэслэлгүй, нэг талыг барьсан байна гэж үзвэл нэхэмжлэгчийн эсрэг сахилга батын хариуцлага тооцуулах саналыг гаргаж болно. Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг холбооны албан ёсны мэдээллийн сувгаар мэдээлнэ.

5.8 Шалгалтын ажиллагааг Ёс зүйн зөвлөлд шилжүүлэх

Хэрэв бие даасан шалгалтын ажиллагааны дараа хэргийг ямар нэгэн байдлаар шийдвэрлэж чадахгүй нөхцөл байдал үүсвэл шалгах ажиллагааг Ёс зүйн зөвлөл өөр дээрээ татан авч бүх гишүүдийнхээ оролцоотойгоор шалгалтын ажиллагааг үргэлжлүүлнэ. Ёс зүйн зөвлөл нь шалгалтын явцад цугласан баримт нотолгоо, мэдээлэл хангалттай гэж үзвэл сонсгол явуулахгүйгээр шийдвэрээ гаргаж болно.

5.9 Хянан шийдвэрлэх ажиллагааг түтгэлзүүлэх

Болзошгүй хориотой зан үйлийн зөрчил нь хууль хяналтын байгууллагын хүрээнд шалгагдаж байгаа бол тухайн шалгалтын үр дүн гартал Ёс зүйн зөвлөл хянан шийдвэрлэх ажиллагааг түтгэлзүүлнэ.

5.10 Нотолгоо хангалтгүй байх

Нэхэмжлэгч зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд туслах боломжгүй болсноос баталгаатай баримт нотолгоо цуглуулах боломжгүй нөхцөл үүсвэл үндэслэл, магадлал бүхий баримтын хүрээнд шийдвэрийг гаргана.

5.11 Зөрчлийн хэргийг нэгтгэх

Нэгээс олон нэхэмжлэгч эсвэл нэгээс олон үйлчлэлд хамаарах этгээдтэй холбоотой гомдол гарсан бол Ёс зүйн зөвлөлийн даргын шийдвэрээр тухайн болзошгүй зөрчлийн хэргийг нэгтгэн шалгаж болно.

5.12 Нууцлал

Болзошгүй хориотой зан үйлийн зөрчлийн талаархи гомдол, шалгах ажиллагаа, шийдвэр, шалгалтын материал, мэдүүлэг, дуу дүрсний бичлэг, бичвэрүүд нь хуульд зааснаас бусад тохиолдолд нууц байна. Энэ заалтыг зөрчвөл хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэж үзэж холбогдох арга хэмжээг авна.

Хүний хувийн нууцтай холбоотой бүх мэдээлэл, бичлэгүүд нь хянан шийдвэрлэх ажиллагаа дууссаны дараа ч нууц байна.

5.13 Мэдээлэх үүрэг

Энэ дүрмийн дагуу үйлчлэлд хамаарах бүх этгээдүүд болзошгүй хориотой зан үйлийн талаархи мэдээллийг Ёс зүйн зөвлөлд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдээлэхгүй байх нь дүрмийн зөрчилд тооцогдоно.

Зургаадугаар зүйл. ШИЙТГЭЛ

6.1 Шийтгэлийн хэм хэмжээ

Хэрэв ёс зүйн зөвлөл хориотой зан үйлийн зөрчил гарсан гэж үзвэл зөрчил гаргасан этгээдэд дараах шийтгэлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн шийтгэлийг ноогдуулж болно.

6.1.1 Анхааруулах

Зөрчил гаргасан дахин зөрчил гаргахгүй байх талаар анхааруулах, дахин зөрчил гаргавал илүү хатуу шийтгэл оногдуулах болно гэдгийг албан ёсоор бичгээр танилцуулах.

6.1.2 Туршилтын хугацаа

Дүрмийг зөрчсөн тохиолдол тодорхой тогтоож өгсөн хугацааны дотор дахин илэрвэл сахилгын нэмэлт шийтгэл ноогдуулах тухай шийдвэр.

6.1.3 Эрх хасах

Үйлчлэлд хамаарах этгээдийн Холбооны үйл ажиллагаа, арга хэмжээ, тэмцээнд оролцох эрхийг тодорхой хугацаагаар хасах.

Эрх хасах хугацаа дууссаны дараа үйлчлэлд хамаарах этгээдийн эрх эргэн сэргэх боловч үйл ажиллагаанд оролцох тодорхой нөхцөл шаардлагыг тавьж болно.

6.1.4 Шийтгэлийн бусад төрөл

МУССХ-ны Ёс зүйн зөвлөл нь өөрийн үзэмжээр бусад төрлийн шийтгэлийг ноогдуулж болно. Үүнд: шагнал урамшууллыг хураах, сургалтанд суулгах, сайн дурын ажил хийлгэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах гэх мэт зөрчлийн шинж чанартай уялдуулан шийтгэлийг оноож болно.

6.2 Шийтгэлийг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх

Зөрчлийн ноцтой байдал болон холбогдох бусад нөхцлөөс шалгаалан шийтгэлийг хөнгөрүүлж эсвэл хүндрүүлэн оногдуулж болно.

Хүндрүүлэх хүчин зүйлүүдэд:

6.2.1 Зөрчлийн хяналт шалгалт, шийдвэрлэх ажиллагааны үеэр хамтран ажиллахаас татгалзсан, саад учруулахыг оролдсон бол

6.2.2 Хориотой зан үйлийн зөрчлийг насанд хүрээгүй хүүхэд эсвэл өөрийн хамаарал, харьяалал, удирдлага доорхи этгээд дээр үйлдсэн

6.2.3 Хориотой зан үйлийн зөрчлийг удаа дараа давтан үйлдсэн

6.2.4 Өмнө энэхүү дүрмэнд хамаарах зөрчлийг гаргаж шийтгэл авч байсан бол

6.2.5 Гаргасан зөрчилдөө гэмшихгүй байх

6.2.6 Ёс зүйн зөвлөлийн гишүүдийн үзэмжээр хүндрүүлэх хүчин зүйл гэж үзэж болох бусад хүчин зүйлс

Хөнгөрүүлэх хүчин зүйлүүдэд:

6.2.7 Зөрчлийн хяналт шалгалт, шийдвэрлэх ажиллагааны үеэр хамтран ажилласан

6.2.8 Гаргасан зөрчлөө цаг тухайд нь хүлээн зөвшөөрсөн

6.2.9 Үйлчлэлд хамаарах этгээдийн өмнөх сахилга батын сайн тодорхойлолт

6.2.10 Үйлчлэлд хамаарах этгээдийн залуу нас, туршлагагүй байдал

6.2.11 Гаргасан зөрчилдөө гэмшиж байгаа байдал

6.2.12 Ёс зүйн зөвлөлийн гишүүдийн үзэмжээр хөнгөрүүлэх хүчин зүйл гэж үзэж болох бусад хүчин зүйлс

6.3 Сургалт, соён гэгээрүүлэх хөтөлбөр

Шийтгэлийн ямар ч хэлбэрийн үед үйлчлэлд хамаарах этгээдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт болон соён гэгээрүүлэх хөтөлбөрт хамрагдахыг шаардаж болно. Мөн бие даасан шийтгэл хэлбэрээр дээрхи хөтөлбөрт хамруулж болно.

6.4 Түтгэлзүүлэх болон сайн дураар түтгэлзэх

Ёс зүйн зөвлөл нь болзошгүй зөрчлийн шалгалтын ажил дуусч, шийдвэр эцэслэн гарах хүртэл хариуцагчийн аюулгүй байдал болон олон нийтийн дунд усан спортын нэр хүндийг унахаас сэргийлж түр түтгэлзүүлэх арга хэмжээг авч болно. Түр түтгэлзүүлэх арга хэмжээг авахаас өмнө хариуцагч өөрийн байр суурийг илэрхийлэх боломжгүй. Ёс зүйн зөвлөлийн шийдвэр гарсан мөчөөс эхлэн түр түтгэлзүүлэх арга хэмжээ хэрэгжиж эхэлнэ.

Хариуцагч нь өөрийнх нь эсрэг үүсгэсэн зөрчлийн шалгалтын ажиллагааг шийдвэрлэгдэж дуусах хүртэл сайн дураараа түтгэлзэж болно. Энэ тохиолдолд хариуцагч нь түтгэлзэх хүсэлтээ Ёс зүйн зөвлөлд бичгээр хүргүүлсэн мөчөөс хориг хязгаарлалт хэрэгжиж эхэлнэ.

Хариуцагч зөрчлийн үйлдэл гаргасан нь тогтоогдвол түүний түр түтгэлзсэн хугацааг (сайн дураар эсвэл бусад хэлбэрээр гэдгээс үл шалтгаална) оноосон эрх хасах шийтгэлийн хугацаанаас хасаж тооцно.

6.5 Зардал

Ёс зүйн зөвлөл өөрөөр шийдээгүй бол шалган шийдвэрлэх ажиллагаа ямар нэг төлбөргүй явагдана. Гэхдээ ёс зүйн зөвлөл нь буруутай нь тогтоогдсон этгээдээр тухайн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор гарсан зардлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж болно.

6.6 Нийтэд мэдээлэх

Хориотой зан үйлийн зөрчлийг шийдвэрлэсэн шийдвэрийг Ёс зүйн зөвлөлөөс хүлээн авсан даруй МУССХ нь олон нийтэд өөрийн харилцаа холбооны сувгуудыг ашиглан мэдээлнэ. Хэрэв үйлчлэлд хамаарах этгээдийг зөрчил гаргаагүй гэсэн шийдвэр гарсан бол зөвхөн түүнийг зөвшөөрсөн тохиолдолд олон нийтэд мэдээлж болно.

Долоодугаар зүйл. ДҮРМИЙН ХЭРЭГЖИЛТ

7.1 МУССХ-ны үйл ажиллагаанд оролцогч бүх үйлчлэлд хамаарах этгээд энэхүү дүрмийг мөрдөж ажиллах үүрэгтэй.

7.1 Холбооны гишүүн байгууллага, клубууд энэхүү дүрмийн хүрээнд өөрийн дүрмийг батлан гишүүдээр мөрдүүлж болно.

7.2 Энэхүү дүрмийн дагуу шийдвэрлэсэн аливаа зөрчлийн шийтгэлийг дэлхийн усан спортын холбоо (World Aquatics) болон түүний үндэсний гишүүн холбоод хүндэтгэж, биелэлтийг нь хангуулахад туслана.

Наймдугаар зүйл. ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

8.1 Хөөн хэлэлцэх хугацаа

Энэхүү дүрмийн дагуу гаргасан нэхэмжлэлийн хөөн хэлэлцэх хугацаа нь хориотой зан үйл болсон гэж үзэж буй сүүлийн огнооноос хойш арван (10) жил байна.

Хэрэв хориотой зан үйл нь нэхэмжлэгчийг насанд хүрээгүй байх үед үйлдэгдсэн гэж үзэж байгаа тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа нь нэхэмжлэгчийг насанд хүрсэн өдрөөс хойш арван (10) жил байна.

Дээр дурдсан хөөн хэлэлцэх хугацаа нь бэлгийн дарамт, хүчирхийллийн нэхэмжлэлд хамаарахгүй.

Зөрчил гаргасан этгээд дүрмийн үйлчлэлд хамаарахгүй болсон, тухайн ажил, үүргээ эрхлэхээ больсон эсвэл чөлөөлөгдсөн ч дүрмийн үйлчлэл зогсохгүй бөгөөд хяналт шалгалтыг энэхүү дүрмийн дагуу явуулж, зохих шийтгэлийг онооно.

Есдүгээр зүйл. ШИЙДВЭРИЙГ ДАВЖ ЗААЛДАХ

9.1 Ёс зүйн зөвлөлөөс зөрчлийн талаар эцсийн шийдвэр гарсны дараа аль нэг тал нь санал нийлэхгүй байвал МУССХ-ны Удирдах зөвлөлд давж заалдах хүсэлтээ өгч болно.

9.2 Давж заалдах хүсэлтийг Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг бичгээр болон цахим шуудангаар илгээсэн өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор Удирдах зөвлөлд хүргүүлсэн байна. Мөн давж заалдах хүсэлтийн хуулбарыг нөгөө талд давхар хүргүүлнэ. Давж заалдах хүсэлтийг Удирдах зөвлөл өөрийн эрх мэдэл, дүрэм журмын хүрээнд шийдвэрлэнэ.

9.3 Удирдах зөвлөлд давж заалдах нь шийтгэлийг түтгэлзүүлэх үндэслэл болохгүй. Удирдах зөвлөлөөс давж заалдахтай холбоотой ямар нэгэн шийдвэр гарах хүртэл тогтоосон шийтгэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.4 Энэхүү дүрмийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй аливаа асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлнэ.

Аравдугаар зүйл. ДҮРМИЙГ ӨӨРЧЛӨХ, ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ

10.1 Энэхүү дүрэмд МУССХ-ны Удирдах зөвлөлийн шийдвэрээр өөрчлөлт оруулж болно.

10.2 Энэхүү дүрмийн заалтуудыг утгын дагуу ойлгон ашиглах бөгөөд бусад хууль тогтоомжтой дүйцүүлэн ашиглахгүй. Дүрмээр хориглосон зарим үйлдэл нь эрүүгийн болон захиргааны хууль

тогтоомжийн эсрэг гэмт хэрэгт тооцогдож болох бөгөөд энэхүү дүрэм нь тухайн хууль тогтоомжийг орлох үүрэг зорилгогүй болно.

10.3 Энэхүү дүрмийн аль нэг хэсгийг дүрмийн бус, хэрэгжүүлэх боломжгүй гэж Удирдах зөвлөл үзвэл зөвхөн тухайн хэсгийг хүчингүй болсонд тооцож дүрмийн бусад зүйл, заалтын хэрэгжилт хэвээр үргэлжилнэ.

10.4 Дүрэмтэй холбоотой аливаа дутагдал, урьдчилан таамаглах боломжгүй нөхцлүүдийг засаж сайжруулах зорилгоор Хүчирхийллийн эсрэг дүрэм болон дүрмийн тухайн зүйл заалтын зорилго, утгыг алдагдуулахгүйгээр нэмэлт өөрчлөлт, найруулгыг хийж болно.

Улаанбаатар

2023 оны 11 сарын 17-ны өдөр